



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯНХУТАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 03 сарын 18 өдөр

Дугаар 8/24

Баянхутаг сум

ХӨРӨНГӨ ЗАРЦУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 2.1.5, 4.1 дахь заалт, Засаг даргын зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 05-ний өдрийн 10 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баянхутаг сумын эмэгтэйчүүдийн зөвлөл, Засаг даргын тамгын газраас хамтарч зохион байгуулсан "Хамтдаа хөгжье" олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийн үйл ажиллагааны зардалд 2.524.906 /Хоёр сая таван зуун хорин дөрвөн мянга есөн зуун зургаа/ төгрөгийг зарцуулж, зардлын тооцоог хавсралтаар баталсугай.


2. Дээрх зардалд шаардагдах 2.524.906 /Хоёр сая таван зуун хорин дөрвөн мянга есөн зуун зургаа/ төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс зарцуулахыг Нягтлан бодогч /Д.Баярмаа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА




Д.БАЙГАЛМАА

Баянхутаг сумын Засаг даргын
2025 оны 13 дугаар сарын
18-ны өдрийн 13 дугаар
Захирамжийн хавсралт



Хөрөнгийн зарцуулалтын задаргаа

№	Нэр	Нэг бүрийн үнэ	Тоо ширхэг	Нийт үнэ /төг/
1	Өнгө тодорхойлох сургалт	1.100.000	1	1.100.000
2	Цайны сэндвич	3.000	200ш	600.000
3	Шаар	12.000	6 уут	72.000
4	MacTea	9.550	3	28.650
5	Maccoff	21.400	2	42.800
6	Аяга /нэг удаагийн/	15.000	1	15.000
7	Том шаар	150	300ш	45.000
8	Fuzetea	4.400	1ш	4.400
9	Meinbra набор	9.900	3ш	29.700
10	Алим	6.600	2,95кг	19.483
11	Мандарин	6.500	0,920	6.006
12	Бараа /бэлгийн сагс/	25.000	3ш	75.000
13	Бэлэг дурсгал	35.000	1ш	35.000
14	Tugalta бэлэг дурсгал	35.000	2ш	70.000
15	Gylgar бэлгийн боолт	2.100	4ш	8.400
16	coffeen	9.600	1ш	9.600
17	300 bar/кофе халбага/	300	3ш	900
18	Ус	800	253ш	202.400
19	Вараа /баглаа боолт/	2.000	3ш	6.000
20	Ванапа чихэр	39.650	3.89 кг	154.567
Нийт				2.524.906



АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2025 оны 03-р сарын 8-ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Гольфийн тэмцээн, арга хэмжээг хөтлөн явуулах гэрээг

Нэг талаас **БАЯНХУТАГ СУМЫН ЗДТ** Газар, Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан 9074449 регистрийн дугаартай, Монгол Улс, Хэнтий аймаг, Баянхутаг сум (цаашид "захиалагч тал" гэх), түүнийг төлөөлж ЗДТГ-ын нягтлан бодогч Д.Баярмаа,

Нөгөө талаас **ГЭРЭЛ ИМИЖ СТАЙЛИНГ СТУДИО ХХК** Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан 8464227 регистрийн дугаартай, Монгол Улс, БГД, 3-р хороо, Жем палас, 1205 тоот оршин суугч (цаашид "гүйцэтгэгч тал" гэх, түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Л. Цолмонгэрэл, цаашид хамтад нь "талууд" гэх) нар нь

Монгол Улсын Иргэний хуулийн 22-р бүлгийг үндэслэн талуудын харилцан тохиролцсоны дагуу дараах байдлаар байгуулав.

1. Нийтлэг үндэслэл

Гэрээг Хэнтий аймгийн, Баянхутаг суманд 2025.3.8-ны өдөр ОУ-ын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийн үйл ажиллагааны хүрээнд бүлгийн сургалт орохоор харилцан тохиролцож байгуулав.

1.1. Энэхүү гэрээгээр Ажил гүйцэтгэгч нь Захиалагчийн даалгаврын дагуу зохион байгуулж буй арга хэмжээн дээр бүлгийн сургалт хийх, нөгөө талаас Захиалагч нь гэрээнд заасан хугацаанд төлбөрийг төлөх, талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Хугацаа:

2025 оны 3-р сарын 8-ны өдрийн 14:00 цагт Хэнтий аймгийн, Баянхутаг сумын соёлын төв.

2. Гүйцэтгэгчийн үүрэг

Гүйцэтгэгч нь дараах үүрэг хүлээнэ.

2.1. Мэргэжлийн түвшинд, чанарын шаардлагад нийцсэн доголдолгүй үйлчилгээг Захиалагчид нийлүүлнэ.

2.2. Арга хэмжээнд 1.2. -т заасан байршилд товлосон хугацаанаас 30 минутын өмнө бэлэн байж тасалдал, доголдолгүйгээр арга хэмжээг зохион байгуулах үүрэгтэй.

3. Захиалагчийн үүрэг

Захиалагч дараах үүрэг хүлээнэ.

3.1. Захиалсан ажлыг гүйцэтгэх хугацаанд чанартай, тогтсон хугацаанд болж буйд хяналт тавьж ажиллана.

3.2. Захиалгат үйлчилгээг доголдолгүй үзүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж (микрофон, дэлгэц гэх мэт) мэдээллийг бүрэн гүйцэд өгнө.

4. Тооцоо хийх нөхцөл

4.1. Гүйцэтгэх ажлын хөлс 1.100,000₮ /Нэг сая нэг зуун мянган/ төгрөг байна.

4.2. Захиалсан ажлын төлбөрийг гэрээ байгуулсны дараа төлөх үүрэгтэй.

5. Давагдашгүй хүчин зүйл

5.1. Гэрээний аль нэг тал давагдашгүй хүчин зүйл / тухайлбал: газар хөдлөлт, үер, гал түймэр, далайн шуурга, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт /-ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас /алданги, торгууль/ чөлөөлөгдөх үндэслэл болно.

5.2. Дээрх давагдашгүй хүчин зүйл бий болсон тухай нотолгоог тухайн орны Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим гэрчилнэ.

6. Бусад заалт

6.1. Гэрээ байгуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. (эсвэл хүчин төгөлдөр болох өдрийг тохиролцож болно)

6.2. Гэрээний хугацаа, нөхцөл байдлын талаар өөрчлөлт оруулахаар бол хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

6.3. Талуудын хооронд маргаан гарвал талууд үл маргах журмаар шийдвэрлэх ба маргаанаа шийдвэрлэж чадахгүйд хүрвэл аливаа маргаантай асуудлыг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Үндэсний Арбитрт түүний Арбитрын Хэрэг Шийдвэрлэх Дүрмийн дагуу Монгол Улсад Эцэслэн шийдвэрлүүлнэ.

7. Нэмэлт нөхцөл

8. Талуудын хаяг

Захиалагч:

Хаяг: Хэнтий аймаг, Баянхутаг сум, Засаг даргын тамгын газар

Утас: _____

Гарын үсэг: _____

Нягтлан бодогч:
/Д.Баярмаа/

Гүйцэтгэгч:

Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 3-р хороо, Жем палас, 1205 тоот

Утас: 8811-3246

Гарын үсэг: _____

Стилист, имижмэйкер
/Л.Цолмонгэрэл/